

ӨТ

M мөр, N багана бүхий тэгш өнцөгт хэлбэрийн шоколадыг өт иджээ. Ингэхдээ зүүн дээд өнцгөөс эхлэн мөрийн төгсгөл хүрдэл идэж, нар зөв эргэн багана (хамгийн арын багана)-ы дагуу үргэлжлүүлэн иддэг. Баганы төгсгөл хүрээд нэр зөв эргэн мөрийг дуустал идээд, нар зөв эргэн баганы дагуу иднэ гэх мэтээр шоколадыг дуустал иджээ. Өт шоколадны нэг нүдийг нэг хазалтаар иддэг.

Тэгвэл шоколадыг идэж дуусгах хүртэлээ өт хичнээн удаа эргэлт хийхийг тооцоолох программ бичээрэй.

Оролтын өгөгдөл

Ганц мөртэй бөгөөд шоколадын мөрийн тоо M, баганы тоо N ($2 \leq M, N \leq 100$) сул зайгаар тусгаарлагдан оршино.

Гаралтын өгөгдөл

Ганц мөртэй бөгөөд өтний шоколадыг идэж дуустал хэдэн удаа эргэх тоог агуулна.

Жишээ

worm.in	worm.out
2 3	2
5 3	5
4 10	6